



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 05 өдөр

Дугаар Б/03

Мандалговь

Б.Нямтуяад ажил түр орлон  
гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.6 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.3.3, 43.3.4 дэх заалт, 43.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.4 дэх заалт, Засгийн газрын "Журам батлах тухай" 2019 оны 9 дүгээр тогтоолын хавсралт "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2, 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Орчны бохирдол, химийн хорт бодис, байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Алтангэрэлийн Ганцэцэгийн жирэмсний болон амаржсаны амралт авсан тул ажлын зайлшгүй хэрэгцээ, шаардлагаар мэргэжилтэн Балжиннямын Нямтуяагийн 2024 оны 08 дугаар сарын 30-ний өдөр гаргасан өргөдлийг үндэслэн 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Орчны бохирдол, химийн хорт бодис, байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт, дотоод ажлыг амралт дуусах хүртэл түр хугацаагаар орлон гүйцэтгүүлсүгэй.

2.Тус мэргэжилтний ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хариуцсан ажлаа чанартай гүйцэтгэх, хэрэгжилтийг цаг тухай бүр тайлагнаж ажиллахыг мэргэжилтэн (Б.Нямтуяад)-д үүрэг болгосугай.

3.Б.Нямтуяад түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын сарын цалинг ТЗ-9-ийн 40 хувь 484,000 (дөрвөн зуун наян дөрвөн мянга) төгрөгөөр тооцож олгохыг ерөнхий нягтлан бодогч (А.Нэргүй)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Н.ГАНТУЛГА



Tushaal B.docx

482401009